

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ 10 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 18 дугаар хуралдаан 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдөр хуралдаж, аймгийн ИТХ-ын анхдугаар хуралдааны тов тогтоох тухай, зөвшөөрөл сунгах тухай асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх 2020 оны 10 дугаар сарын 08-ны өдөр тус аймагт ажиллаж, Баруун бүсийн хөгжлийн зам Баянхонгор-Алтай чиглэлийн 126,7 км хатуу хучилттай автозамыг ашиглалтад хүлээж авах, иргэдтэй уулзаж, аймгийн эдийн засаг, нийгмийн өнөөгийн байдалтай газар дээр нь танилцах, иргэд хөдөлмөрчидтэй уулзаж, санал хүсэлтийг сонсон, чиглэл өгч ажиллалаа.

Цагаан идээг үйлдвэрийн аргаар боловсруулах сүү, сүүн бүтээгдэхүүний цех Бүгд Найрамдах Турк Улсын Туркийн хамтын ажиллагаа, зохицуулах агентлаг (ТИКА)-ийн 34.5 мянган долларын санхүүжилтээр тус аймагт байгуулагдаж, 11 өрхийн 20 гаруй иргэн байнгын ажлын байртай боллоо.

Тайлант хугацаанд Баруун бүс нутгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэдэг төрийн өмчит АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь Анагаах ухааны сургуулийн хичээлийн шинэ байрны барилгыг улсын төсвийн 6.5 тэрбум төгрөгийн санхүүжилтээр “Манхан-Уст” компани, “Усан спорт чийрэгжүүлэлтийн төв”-ийн барилгын ажлыг улсын төсвийн 4.3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр “Биг Монголиа билдинг” ХХК, Шарга сумд хоёр давхар орчин үеийн техник, технологи бүхий 10 ортой эрүүл мэндийн төвийн шинэ барилгыг улсын төсвийн 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр “Жи Ти Кэй Эс” ХХК, Есөнбулаг сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг “Арвин-Өргөө” компани улсын төсвийн 979. 0 сая төгрөгийн санхүүжилтээр тус тус гүйцэтгэж ашиглалтад орууллаа.

Мөн Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын хөнгөлттэй зээлийн хүрээнд хэрэгжүүлсэн “Онцгой байдлын албаны гамшигтай тэмцэх техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Монгол орны цаг агаарын эрс, тэс уур амьсгал, газар нутаг, автозамын хүнд нөхцөлд тохируулан нэмэлт тоног, төхөөрөмжөөр тоноглогдсон, орчин үеийн дэвшилтэт технологи бүхий аврах ажиллагааны багаж, хэрэгсэл суурилуулсан гал унтраах тусгай зориулалтын автомашинтай боллоо.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 190 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төрийн байгууллагууд 2020 онд хийсэн ажлаа сурталчилах, төрийн үйлчилгээг нэг дороос хүргэх, иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах зорилгоор “Нээлттэй хаалганы өдөр” арга

хэмжээг 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдөр зохион байгууллаа. Тус арга хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн 48 байгууллага оролцож, үйл ажиллагаагаа сурталчилж, үйлчилгээ үзүүллээ. Мөн 2020 оны хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлаа танилцуулж, 156 иргэний санал, хүсэлт, 1500 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авч, 63 төрлийн үйлчилгээг үзүүлж, 800 гаруй иргэн хамрагдлаа.

Үйлчилгээний нэгдсэн төв нь 162 нэр төрлийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд нэг цэгээс түргэн шуурхай хүргэн, 7800 иргэн үйлчилгээ авсан байна. Тайлант хугацаанд 24 өргөдөл ирсний 8 өргөдлийг шийдвэрлэж, 16 өргөдлийн хугацаа болоогүй судлагдаж байна. Шийдвэрлэлт нь 33.33 хувьтай байна.

“Иргэдээ сонсох нээлттэй утас 7048-1111” дугаарын утсанд 49 дуудлага хүлээн авснаас, хувийн мэдээллээ бүрэн өгч “E-Office” программд бүртгэгдсэн 12 санал, хүсэлтийг холбогдох байгууллагуудад шилжүүлэн, хяналт тавин шийдвэрлүүллээ. Хугацаа болоогүй судлагдаж байгаа 6 өргөдөл байна. Шийдвэрлэлт 50.0 хувьтай байна.

Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс нийт 466 лавлагаа олгож, төсөвт 558.500 төгрөгийг төвлөрүүллээ.

Тус аймаг дахь Төрийн аудитын газраас өмнөх онуудад тогтоосон акт, албан шаардлагын биелэлтийг хангуулах ажлын төлөвлөгөө гаргаж, төрийн байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Төрийн аудитын газрын 2019 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтад хийсэн аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж, 390.0 мянган төгрөгийн актын төлбөрийг барагдууллаа.

Тайлант хугацаанд 2 дугаар ээлжийн цэрэг татлагын ажлыг Монгол Улсын Засгын газрын тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар 10 дугаар сарын 05-ны өдрөөс 22-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Цаг уур орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин тус аймагт ажиллаж, зайлшгүй шалтгааны улмаас үүссэн 770.0 мянган төгрөгийн өр, албан хаагчдад зэргийн нэмэгдлийг цаашид үргэлжлүүлэн олгох, компьютер, принтер, термометр, автомат станц зэрэг тоног төхөөрөмжийн асуудлыг тус тус шийдвэрлэлээ.

Тус аймгийн Бугат, Алтай сумдын нутаг дэвгэрт 10 дугаар сарын 14,21,28 өдрүүдэд зорчигчийн жижиг оврын онгоц нисэх болсонтой холбогдуулан бүх төрлийн урьдчилсан мэдээний хангалтыг хийж байна.

ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн Засаг дарга бүрэн эрхийнхээ хүрээнд 10 дугаар сард 60 захирамж гарган, шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор захирамжийг скайнердаж, аймгийн албан ёсны www.govi-altai.gov.mn сайтад байршуулж хэвшээд байна.

Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 3/1543 дугаар албан

бичгээр Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэст хүргүүллээ. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 57 дугаар тогтоолыг хүчингүй болгуулах тухай “Алтай Ложистик” ХХК-ийн нэхэмжлэлтэй хэрэгт холбогдох нотлох баримтыг бүрдүүлэн тус аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд албан бичгээр хүргүүллээ.

Архивын тасаг: Архивын баримтаас иргэдийн хүсэлтийн дагуу 269 иргэнд мал тооллогын, цалингийн, тушаалын лавлагаа гаргаж, мал тооллогын болон цалин, тушаалын 4250 хуудас хуулбар олгон Төрийн архиваас үзүүлэх төлбөрт үйлчилгээний үнийн тарифын дагуу 4713.7 мянган төгрөгийн хураамжийг төрийн сангийн дансанд төвлөрүүллээ.

Баян-Уул, Дарив, Дэлгэр сумын малын А дансны 3 хадгаламжийн нэгжийн 7784 хуудас баримтыг засварлалаа.

Улсын бүртгэлийн чиглэлээр: Иргэний бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд шуурхай чирэгдэлгүй, чанартай хийж цахим мэдээллийн санг эрхлэн хөтөлж тухай бүр баяжилтыг хийж гүйцэтгэж ажиллалаа. Тайлант хугацаанд лавлагаа олголт 348, гадаад паспорт захиалга 9, нийт 357 үйлчилгээ үзүүлсэн байна. Өдөр тутмын үйл ажиллагаандаа хууль журмыг тогтмол мөрдөж хуулийн талаарх брошур, гарын авлагыг иргэдэд хүргэн, үйлчилгээний зааланд байршуулан, сурталчиллаа.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр: Иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийн 316 мэдүүлэг хүлээн авч шийдвэрлэлээ. Иргэд, хуулийн этгээдээс бүртгэлийн үйлчилгээний хураамж 4231109 төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 171978 төгрөг, татварын орлого 8186712 төгрөгийг тус тус улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүллээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр: Тайлант хугацаанд хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой хуулиуд, хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам, хуулийн этгээдийн нэр олгох журам, лавлагаа олгох журам, хувийн хэрэг хөтлөх журам болон байгууллагын стандартыг мөрдөн ажиллаж, шинээр бүртгүүлж хуулийн этгээдийн гэрчилгээ авсан 5, дахин олгосон гэрчилгээ 34, нийт 39 гэрчилгээг бүртгэлээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд шуурхай, чирэгдэлгүй хийж, цахим мэдээллийн санг эрхлэн хөтөлж тухай бүр баяжилтыг хийж гүйцэтгэж байна.

Хяналтын чиглэлээр: Тайлант хугацаанд хяналт шалгалтын ажил хууль, журам, байгууллагын стандартын хүрээнд явагдаж, иргэний улсын бүртгэлийн тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй тогтоосон журам зөрчсөн үйлдэлд хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж 39 иргэнд 875.0 мянган төгрөгийн торгууль ногдууллаа. Мөн Иргэний бүртгэлийн чиглэлээр 11, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл 7, Хуулийн этгээд 3,

нийт 21 дүгнэлтээр зөрчлийг арилгаж шийдвэрлэлээ. Бичиг баримтын зөрчилтэй иргэдээс 2 өргөдөл хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэж зөрчлийг арилгалаа.

ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ, ХУДАЛДАН АВАХ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Эхний 10 сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсөвт 5022.1 сая төгрөг төвлөрүүлэхээс 5386.7 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 107.3 хувиар, улсын төвлөрсөн төсөвт 904.3 сая төгрөг төвлөрүүлэхээс 865.2 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 95.7 хувиар биелүүллээ.

Улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээр 13245.0 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр 26347.0 сая төгрөгийг бүрэн авч сум, байгууллагуудын дэмжлэгийг бүрэн олголоо.

Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 1, Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 1, Улсын төсвийн хөрөнгөөр 1, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2, нийт 5 тендерийг зарлалаа.

Орон нутгийн замын сангийн хөрөнгөөр зогсоол хийх, хатуу хучилттай автозамын босоо тэмдэг тэмдэглэгээ, хатуу хучилттай автозамын хэвтээ тэмдэглэгээ, хатуу хучилттай автозамын нөхөөс хийх тендерүүдийг дахин зарлалаа.

Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх Есөнбулаг сумын Ахмадын холбоо, сувиллын барилга барих, Дэлгэр сумын шинээр баригдсан сургууль, цэцэрлэгийн барилгын дэд бүтэц, халаалтын зуухны ажлын тендерийг тус тус шууд гэрээ байгуулахаар зөвлөмжийг хүргүүллээ.

Улсын төсвийн хөрөнгөөр “Алтай” чуулгын хуучин барилгыг “Багшийн хөгжлийн ордон” болгож өөрчлөх, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх Соёл амралтын хүрээлэнг тохижуулах ажлын тендерийн гүйцэтгэгчийг тус тус сонгон шалгаруулж, гэрээ байгуулах эрх олголоо.

ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хөдөө аж ахуйн газрын албан хэрэгцээнд зориулан LADA-2131 маркийн туулах чадвар сайтай суудлын автомашин, байгууллагын гадна төмөр хашаа хийх ажлын, нийт 15.0 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэлээ.

Мал аж ахуйн салбарт: Аймгийн ихэнх нутгаар гантай байснаас бэлчээрийн ургамлын ургалт муу, бэлчээрийн даацыг нийт нутгаар тооцоолж гаргахад 78.0 хувь нь бэлчээрийн хүрэлцээгүй, Улсын Онцгой комиссын дүгнэлтээр ган зудын эрсдэлийн үнэлгээ хийхэд “Их эрсдэлтэй” гэж тогтоогдсон.

Өндөржүүлсэн бэлэн байдлын үед аймгийн хүнс хөдөө аж ахуйн салбарт авах зарим арга хэмжээний тухай аймгийн Засаг даргын А/598, аймгийн аюулгүй нөөцөд бэлтгэсэн өвсийг

худалдан борлуулах тухай А/599, аймгийн аюулгүй нөөцөд өвс, тэжээл бэлтгэх тухай А/600 дугаар захирамжийг тус тус гарган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангалтыг Хүнс хөдөө аж ахуйн сайдын 2016 оны А-71 дүгээр тушаалаар батлагдсан “Мал өвөлжилтийн бэлтгэл хангах, шалгах, дүгнэх” зааврын дагуу дүгнэхэд малын тарга хүч 80.4 хувь, сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэлт 27.0 хувь, аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэлт 27.0 хувь, худгийн бэлэн байдал 95.0 хувь, малын усан хангамж 97.0 хувь, хашаа бууцны хангамж 97.0 хувь, өрхийн өвөлжилтийн бэлтгэл 85.0 хувь, аймгийн дүнгээр өвөлжилтийн бэлтгэл хангалт 67.0 хувьтай байна. Мал аж ахуйн өвөлжилтийн нэгдсэн дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт албан бичгээр хүргүүллээ.

Аймгийн хэмжээнд зуншлага муу, гантай байснаас бэлчээрийн ургамлын ургалт муу, бэлчээрийн даац хэтэрсэн зэрэг хүчин зүйлээс шалтгаалан өвөлжилт хүндрэхээр байгаа тул аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг 10 дугаар сарын 06, 07 ны өдрүүдэд Баян-Уул, Хөхморьт, Дарив сумдад ажиллаж, отроор явж байгаа малчдын нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, холбогдох мэргэжилтнүүд болон отроор яваа малчидтай биечлэн уулзаж тулгамдаж буй асуудлын талаар санал солилцож, шийдвэрлэх арга хэмжээг авч ажиллалаа. Үүнд: Отроор явж байгаа малчин өрхүүдийг бэлчээрийн даацад тулгуурлан тухайн газар нь өвөлжүүлж, хаваржуулах нөхцөл бололцоогоор хангах, эрүүл мэндийн болон бусад төрийн үйлчилгээг үзүүлэх талаар сумдын удирдлагуудад албан бичгээр чиглэл хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

10 дугаар сарын 28-ны байдлаар Улсын тусгай хамгаалалттай бүс нутагт 4 сумын 273 малчин өрхийн 307.8 мянган толгой мал, хилийн зурваст 2 сумын 101 өрхийн 69.0 мянган толгой мал, Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бүс нутагт 1 сумын 15 өрхийн 4.6 мянган толгой мал тус тус өвөлжиж, хаваржих урьдчилсан судалгаа гараад байна. Мөн өөр аймгийн нутагт 8 сумын 92 өрхийн 46.0 мянган толгой мал, өөрийн аймгийн бусад сумын нутагт 11 сумын 461 өрхийн 258.0 мянган толгой мал отор нүүдэл хийж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 8 сумын 42 цэгт газрын доорх уст цэгийн хайгуулын ажлыг “Ус-Амьдрал” ХХК хийж гүйцэтгэлээ.

Тус аймгийн 18 сумын 1510 малчны 879.6 тн хонины ноос, 91.6 тн тэмээний ноос, нийт 971.3 тн ноосонд 1582.8 сая төгрөгийн урамшуулал олгогдох тооцооллыг нэгтгэн, Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүллээ.

Мал, мах бэлтгэлийн хүрээнд: Аймгийн төвийн хүн амын 2021 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан махны нөөц бүрдүүлэхээр аймгийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 23-ны А/593 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Засгийн газрын хуралдаанаар өвөлжилт хүндэрсэн аймгуудаас экспортод 40.0 тн мах гаргах шийдвэр гарсантай холбогдуулан сумдаас зах зээлд борлуулах мал, махны судалгааг авч нэгтгээд байна. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар өвөлжилт хүндэрсэн аймгуудаас дундаас доогуур тарга хүчтэй малыг нядалж, борлуулах ажлын хүрээнд судалгааны ажлын хэсэг тус аймагт ажиллаж, Бигэр, Дэлгэр, Чандмань, Эрдэнэ, Цогт, Халиун, Есөнбулаг сумдаас дундаас доогуур тарга хүчтэй малын судалгааг гарган Хөдөө аж ахуйн бирж, болон Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэн, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Газар тариалангийн салбарын хүрээнд: Аймгийн 2020 оны ургац хураалтын мэдээг гарган ХХААХҮ-ийн яамны ГТБХЗГ-т хүргүүллээ. 2020 онд үр тариа 382 га-аас 552.9 тн, төмс 87.1 га-аас 550 тн, хүнсний ногоо 68 га-аас 565 тн, ногоон тэжээл 746 га-аас 2100.3 тн, жимс, жимсгэнэ 102 га-аас 68 тн, эмийн ургамал 131 га-аас 0.5 тн, нийт 1520.7 га-аас 3837 тн ургац хураан авлаа. Аймгийн “Атар 4 газар тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ны 2020-2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсрууллаа. Мөн Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хүрээнд Халиун сумын Ёлтонгийн услалтын системийн зураг төсвийг хийх ажлын суурь судалгааг хийсэн.

Зохион байгуулалтын чиглэлээр хийгдсэн ажил: Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн 2020 оны 10 дугаар сарын 8-ны өдөр тус аймагт ажиллаж, холбогдох албан хаагчидтай уулзан, мал махыг эдийн засгийн эргэлтэд оруулахад халдваргүйтгэл, урьдчилан сэргийлэх ажил хамгаас чухал болохыг анхааруулж, малын насжилт өндөр байгаа нь экологид сөргөөр нөлөөлж буйг онцлон энэ байдлыг малчдад ойлгуулан, малын таваарлаг байдлыг сайжруулах, малын өвчнөөс урьдчилан сэргийлж тарилга туулгалт, вакцинжуулалтад бүрэн хамрагдахын ач холбогдол зэргийг малчдад сурталчилан таниулах соён гэгээрүүлэх ажил хийхийг үүрэг болголоо.

Мал эмнэлгийн чиглэлээр: Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлийн дүн

| № | Халдварт өвчний нэр | Хамрагдах мал, амьтны тоо | Мал эмнэлгийн цахим нэгдсэн системд | | |
|---|---------------------|---------------------------|-------------------------------------|-----------|-------|
| | | | Төлөвлөлтийн дүн /хувиар/ | Гүйцэтгэл | Хувь |
| 1 | Галзуу | 110100 | 100% | 109096 | 99.08 |
| 2 | Боом | 69200 | 100% | 69168 | 99.9 |
| 3 | Цусан халдварт | 131400 | 100% | 128759 | 98.0 |
| 4 | Дуут | 5000 | 100% | 4916 | 98.3 |
| 5 | ДХХ энтербактериоз | 412000 | 100% | 404319 | 98.1 |

| | | | | | |
|-------------|--------------|----------------|-------------|----------------|-------------|
| 6 | Адууны сахуу | 8100 | 100% | 7600 | 93.8 |
| 7 | Сохор догол | 101080 | 100% | 101176 | 100 |
| 8 | Шөвөг яр | 299400 | 100% | 296321 | 98.9 |
| Нийт | | 1136280 | 100% | 1121355 | 98.6 |

Бруцеллёз өвчний вакцинжуулалтад /Штам-19/ 17744 тугал, /PEB-1/ 257723 хурга, 524239 ишиг, нийт 799706 төл хамрагдахаас /Штам-19/ 15798 тугал, /Рев-1/ 256969 хурга, 490316 ишиг, нийт 763083 толгой төл малыг хамруулж, гүйцэтгэл 95.42 хувьтай байна.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах мал, амьтны төлөвлөлт, гүйцэтгэлийг мал эмнэлгийн нэгдсэн цахим системтэй тулган вакцинжуулалтын материалыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдээс хүлээн авч дууслаа.

Мал эмнэлгийн нэгдсэн системийн Мал эмнэлгийн гарал үүслийн гэрчилгээний бичилтэд өдөр тутмын хяналт цахимаар хийж байна. Тайлант сард нийт 1107 гэрчилгээ бичигдэж, бусад аймаг, сумруу гарсан 712, гаднаас ирсэн 78, аймаг дотроо 317 гэрчилгээ бичигдсэн болно.

Мал эмнэлгийн лабораторид хийгдсэн ажил: Баян-Уул сумын Алтангадас багт галзуу өвчин оношлогдож, хязгаарлалтын дэглэм хэрэгжүүлэн ажиллалаа.

Ариун цэврийн магадлан шинжилгээнд 600 кг мах, бэтэг өвчний тандах шинжилгээнд 10 нохой, нийлүүлгийн өвчний шинжилгээнд 1 адуу хамрагдаж шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа.

Бруцеллёз өвчний шинжилгээ хийж, тайлан, гэрээ дүгнэсэн акт зэргийг Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторид хүргүүлээ.

ТАВ. БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг 5 байршил газарт зарлаж, газрын цахим биржийн системээр зохион байгуулж, 3 байршил газарт 1 оролцогчтой дуудлага худалдаа амжилтгүй болж. 2 байршил газарт нийт 8 оролцогч оролцож, 2 нэгж талбарт ялагч тодорч гэрээ байгууллаа.

Газрын үнэлгээний систем орон даяар нэвтрүүлэх ажлын хүрээнд газрын цахим биржийн системд 496 нэгж талбарын үнийн мэдээг оруулж, 131 нэгж талбарыг байршилтай холбох ажил хийгдлээ.

Улаанбаатар хотод зохион байгуулагдсан газрын үнэлгээний системээр газрын эдийн засгийн үнэлгээ хийх тухай сургалтад 1 албан хаагч хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүллээ. Уг сургалтыг сумдын газрын даамлуудад зохион байгуулан чиглэл, мэдээлэл өглөө.

Барилга, хот байгуулалтын чиглэлээр: Геодези, зураг зүйн газраас зохион байгуулсан “Хот байгуулалтын кадастрын цахим систем”-ийн сургалтад 2 албан хаагч, Барилга, хот

байгуулалтын яамнаас зохион байгуулсан “Улсын барилгын чанарын зөвөлгөөн”-д 1 албан хаагч тус тус хамрагдаж, мэдлэг, чадвараа дээшлүүлээ.

Есөнбулаг сумын Баяншанд багийн шинэ худгийн хамгаалалтын бүс хийх ажилд 2020 оны 10 сарын 14-ны өдөр, Алтай сумын Соёлын төвийн засвар болон Засаг даргын тамгын газрын барилгын ажилд 2020 оны 10 сарын 28-ны өдөр тус тус комисс ажиллаж үүрэг даалгавар өглөө.

“Мэдээлэл холбоо сүлжээ” ТӨХК-ийн баруун талаас хүүхдийн ордон хүртэлх 310 м цутгамал бетон замын ажлыг 2020 оны 10 сарын 26-ны өдөр, Хүнхэр зуслангийн байрнуудын их засварын ажлыг 2020 оны 10 сарын 27-ны өдөр тус тус комисс ажиллаж, ашиглалтад хүлээжн авлаа .

ЗУРГАА. НИЙГМИЙН САЛБАР:

Боловсрол, соёл, урлагийн салбарт: 2020 оны 10 дугаар сарын 07, 08,09-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, мэдээллийн технологи” сэдэвт Удирдлагын академийн захиалгат сургалтад холбогдох албан хаагчид хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлээ.



Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судалж, хамтран ажиллах уулзалт, сургалтад хамрагдлаа.



Тус аймаг эмэгтэй хөл бөмбөг хөгжүүлэх аймгаар шалгарч 3.2 сая төгрөгийн хэрэглэл материалыг хүлээн авч, бэлтгэл сургуулилтаа хийж байна.

Боловсролын үйлчилгээний талаар иргэдээс санал асуулга авч, нэгтгэн дүгнэлээ. Санал асуулгад ерөнхий боловсролын 6 сургууль, 5 цэцэрлэгийн нийт 32 эцэг эх хамрагдлаа. Санал асуулгын дүнг нэгтгэхэд: Үйл ажиллагаагаа олон нийтэд сурталчилах, мэдээлэх, багш, боловсон хүчнийг анхаарах, удирдах албан тушаалтныг тогтвор суурьшилтай ажиллуулах, мэдээллийг нээлттэй, ил тод болгох талаар цаашид анхааран ажиллах шаардлагатай гэсэн санал ирүүлснийг үйл ажиллагаандаа тусган ажиллахаар төлөвлөж байна.

Хөдөлмөр эрхлэлт: Аймгийн хэмжээнд нийт 984 иргэн ажил хайгчаар бүртгэлтэй байгаа бөгөөд тайлант сард 19 иргэн ажлаасаа чөлөөлөгдөж, ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолт авлаа. ХХҮГ-т нийт 7 аж ахуйн нэгж, байгууллагаас 73 сул чөлөөтэй ажлын байрны захиалга ирснийг иргэдэд нээлттэй мэдээлж, захиалгын дагуу 23 иргэнийг ажлын байранд зуучлан ажилд орууллаа.

Нийгмийн халамжийн сангийн мэдээлэл: Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас дараах тэтгэвэр тэтгэмжийг олголоо. Үүнд: Халамжийн тэтгэвэр 1409 иргэнд 387.8 сая, нөхцөлт мөнгөн тэтгэмж 1119 иргэнд 97.9 сая, амьжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 265 иргэнд 60.9 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж 353 иргэнд 41.5 сая, ахмад настны хөнгөлөлт, тусламж 198 иргэнд 30.2 сая, жирэмсэн эхийн тэтгэмж 441 иргэнд 17.2 сая, цалинтай эхийн тэтгэмж 2576 эхэд 126.9 сая, алдарт эхийн одон 135 эхэд 13.5 сая, алдар цолтой ахмадын хөнгөлөлт 30 иргэнд 9.0 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээг тус тус үзүүллээ.

Нийгмийн даатгал: Нийгмийн даатгалын сангаас үйлчилгээ авагч иргэдийн тэтгэврийг 10 дугаар сарын 01-нд багтаан олгож, олгогдоогүй тэтгэвэр тэтгэмжийн өглөггүй ажиллалаа. Аймгийн хэмжээнд өндөр насны тэтгэвэр авагч 9176 хүнд 3116.8 сая төгрөгийг олголоо. Шинээр тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан өндөр настан 85, тахир дутуу 48, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 6, нийт 139 даатгуулагчийн тэтгэврийн баримт материалыг хүлээн авч, хуулийн хүрээнд шийдвэрлэлээ.

Тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсэн амаржсаны тэтгэмж 21 хүнд 34.5 сая, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 39 хүнд 5.6 сая, оршуулгын тэтгэмж 6 хүнд 6.0 сая, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмжид 23 хүнд 33.7 сая төгрөгийг тус тус олголоо.

Сайн дурын даатгалд нийт 45 хүн хамрагдсанаас 41 хүн ажилгүй, 0-3 насны хүүхдээ асарч буй 4 эхийг хамрууллаа.

Эрүүл мэндийн даатгалд 435 иргэнийг хамруулж, 22.6 сая төгрөг ЭМД-ын санд хуримтлагдлаа.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлыг цахимаар зохион байгуулж, 116 хүн орж, үүнээс шинээр 23 хүн хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгож, 93 хүний групп сунгагдлаа.

НҮБ-ын Хүүхдийн сангийн “Хүүхдэд-Ээлтэй орон нутаг” хөтөлбөрийн хүрээнд хүүхдийг цахим орчны эрсдэлээс хамгаалах, тэдэнд цахим орчны зөв зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор 2020 оны 10 дугаар сарын 29-нд “Гэрэлт цамхаг сан Монгол” ТББ-тай хамтран "Digital Literacy" сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгууллаа.

Эрсдэлт нөхцөлд байгаа 100 хүүхдийг даатгалын үйлчилгээнд хамрууллаа.

2020 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын хөгжлийн төвөөс зохион байгуулсан цахим сургалтад 4 албан хаагч оролцон мэдлэг, чадвараа дээшлүүллээ.

Хүчирхийлэл үйлдэгчийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн тогтвортой байдал, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэх, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, өөрийгөө тайвшруулах чадвартай болох, амьдралын эерэг хандлага, зөв дадал төлөвшүүлэх зорилготой зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг аймгийн Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газруудад 4 удаа зохион байгуулж, нийт 18 хүнийг хамрууллаа.

“Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр 7, “Гэр бүлд зөвлөгөө өгөх төв”-өөр 17 хүн, нийт 24 хүнд нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг үзүүллээ.

Шатрын холбооноос уламжлал болгон зохион байгуулагддаг өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2020 оны 10 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, 8 сумын 12 сургууль, 20 цэцэрлэгийн нийт 120 тамирчин 7 насны ангиллаар өрсөлдөж, 63 өсвөрийн шатарчид шагналт байранд шалгарлаа.

Эрүүл мэндийн салбарт: Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 10 сарын байдлаар 1173 эх нярайлж өнгөрсөн оны мөн үеэс 29 тохиолдол буюу 2.5 хувиар, 1182 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 24 хүүхдээр буюу 2.1 хувиар тус тус өсчээ. Нас баралтын 234 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 19 тохиолдлоор буурсан байна. Нас баралтын 4.3 хувийг нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 32.5 хувийг хорт хавдрын шалтгаант, 17.1 хувийг осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт тус тус эзэлж байна.

Ковид-19-тэй холбоотой цаг үеийн мэдээллийг www.burtgel.mohs.mn-аар нэвтрэн нэгж байгууллагаас ирүүлсэн өдөр бүрийн мэдээг 10 дугаар сард 31 удаа хянан баталгаажуулж, нэгтгэн, Эрүүл мэндийн хөгжлийн төвд илгээлээ.

ДЗМОУБ-тай хамтран Ерөнхий боловсролын 4 сургуулийн 835 хүүхдэд Коронвируст халдвар /COVID-19 / -аас урьдчилан сэргийлэх зорилгоор “Цэвэр гар-цагаан алчуур “ гар угаалтын сургалтыг зохион байгуулж, мэдлэг олголоо.

Геронтологийн үндэсний төвтэй хамтарсан цахим сургалтыг 3 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 20 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдан, ахмад настанд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх талаар мэдлэгтэй боллоо.

Улаанбаатар хотод Эрүүл мэндийн салбарын шинэчлэл, бодлогын хэрэгжилтийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зам, эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэл, гүйцэтгэлийн санхүүжилт” сэдэвт сургалтад холбогдох албан хаагчид хамрагдан, чадавхжлаа.

Азийн хөгжлийн банкны "Вируст гепатит, сүрьеэгийн төсөл", ХӨСҮТ хамтран Сүрьеэгийн илрүүлэлт, урьдчилан сэргийлэлт, оношилгоо, эмчилгээ, хяналтыг сайжруулахад эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын чадавхыг сайжруулах сургалт зохион байгуулж нийт 76 хүн хамрагдаж, чадавхжлаа.

Эрүүл мэндийн газар, УГТЭ, Нэгдсэн эмнэлэг хамтран "Коронавируст халдварын хариу арга хэмжээ ба сувилахуйн тусламж үйлчилгээний бэлэн байдал" сэдэвт онол, дадлага хосолсон сургалтыг 2020 оны 10 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд зохион байгуулж, коронавирус халдварын үеийн бэлэн байдал, яаралтай тусламж, эрчимт эмчилгээ, харвалт, зүрхний шигдээсийн сувилахуйн чиглэлээр 160 гаруй сувилагч мэргэжилтнүүдэд онолын болон дадлага сургалтыг зохион байгуулж, мэдлэг, ур чадвараа дээшлүүллээ.

Коронавируст халдвар (COVID 19)-ын сэргийлэлт, хяналт, эмнэлгийн бэлэн байдалд үнэлгээ өгөх, эмнэлзүйн сургагч багш бэлтгэх зорилгоор Эрүүл Мэндийн Яам, аймгийн Эрүүл мэндийн газар, ХӨСҮТ, ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын хүн амын сан, АШУҮИС хамтарсан сургалтыг 10 дугаар сарын 5-ны өдөр зохион байгууллаа. Тус сургалтад Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, тусгай эмнэлэг, аймаг дүүргийн Нэгдсэн эмнэлэг, амаржих газрууд, сувилал, сэргээн засах төв, өрх, сум, тосгоны ЭМТ, Клиник гэсэн чиглэлийн эрүүл мэндийн салбарын 27 ажилтан албан хаагчид хамрагдлаа.

ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголын зочид буудлын холбоо хамтран тус аймагт Зочлох үйлчилгээний төрөлжсөн сургалтыг 10 дугаар сарын 05-ны өдрөөс 09-ний өдрүүдэд 10 чиглэлээр зохион байгуулж, мэргэжлийн гэрчилгээ олголоо. Сургалтад нийт 270 гаруй иргэн хамрагдаж, ур чадвараа дээшлүүллээ.



/ зураг 1.Зочлох үйлчилгээний төрөлжсөн сургалт тус аймагт зохион байгуулагдлаа.

“Ай ти эм Монголиа -2020” үзэсгэлэн 10 дугаар сарын 28-ны өдрөөс 31-ний өдрүүдэд “Аялал жуулчлал ба орон нутгийн хөгжил” уриан дор 21 дэх жилдээ зохион байгуулагдлаа.

Тус “Ай ти эм Монголиа-2020” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгийн түнш аймгаар Хэнтий аймаг оролцож, нийт 200 гаруй аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага үйл ажиллагаагаа болон орон нутгаа сурталчилан, давхардсан тоогоор 6000 гаруй хүн үзэж сонирхлоо.

Үзэсгэлэнгийн үеэр аймгийн аялал жуулчлалын сэтгүүл 150ш, аялал жуулчлалын маршрутын танилцуулга 300ш, тус аймгийн брэнд эвент арга хэмжээ болгохоор зорин

ажиллаж буй “Элсний фестиваль-2021” арга хэмжээний 500 ширхэг материалыг иргэдэд хүргэн сурталчиллаа.



Зураг 3. ITM -Mongolia 2020 ОЛОН УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЗЭСГЭЛЭНД ГИДЦГ-ын А. Б хэсгийн хамгаалалтын захиргаатай хамтран "Монголын говийг дэлхийд таниулна" уриатайгаар аймаг орон нутгаа сурталчиллаа

"Ногоон хөгжлийн" бүлгийг боловсруулахад анхаарах асуудлын талаар "Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтийг хангах нь" төслийн зөвлөхүүд тус аймагт ажиллаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.



Зураг 4. Сургалт уулзалтын үеэр

НАЙМ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Боловсрол, соёл, эрүүл мэнд, хүнсний чанар, эрүүл ахуйн хяналтын хүрээнд:

Эрүүл ахуй халдвар хамгаалын хяналтаар:Бургастай хилийн боомтын Алтайн хүдэр ХХК-д хилийн халдваргүйтгэлийн арга, халдваргүйтгэлд хэрэглэх бодисын талаар зөвлөмж өглөө. Аймгийн МХГ, ЭМГ, Тагнуулын хэлтэс хамтран "Баптист" сүм , "Алтайн оюуны хөгжил" ТББ-д эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэм, халдваргүйтгэлийн бодисын хэрэглээ, халуун хэмжилт, амны хаалт, санитолын хэрэглээ зэрэгт хамтарсан хяналт хийн заавар зөвлөгөө өгч, цаашид авах арга хэмжээний талаар 12 заалттай зөвлөмж хүргүүллээ.

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх аймагт ажиллах үеэр орчин, хүнсний эрүүл ахуйн хяналтын чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналт хийн хоол, хүнсний 8 дээж авч Нэгдсэн лабораторид шинжлүүлэн улсын байцаагчийн дүгнэлт үйлдэн Тагнуулын хэлтэст хүргүүллээ.

Байгаль орчин, уул уурхай, хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгаалал, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:

Автотээвэр, өргөх механизмын хяналтаар: Нийт 10 байгууллага, аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хяналт хийж цахим системд бүртгэлээ. 5 объект эрсдэлийн “дунд” ангиллаас “бага” ангилалд шилжиж, эрсдэл үүсэх магадлал 26.0-29.0%, хууль тогтоомжийн хэрэгжилт дунджаар 84.0%-тай байна.

Хэмжил зүйн хяналтаар: Аймгийн Стандарт хэмжилзүйн газрын хүсэлтээр Шинэ-Алтай захын ил талбайд борлуулагдаж байгаа мах, ногоонд ашиглагдаж буй 12 жинд хамтарсан шалгалт хийж, 11 жинг улсын баталгаажуулалтад хамрууллаа.



Нэгдсэн лаборатори:Лабораторид 9 байгууллага, 17 аж ахуй нэгж, 17 иргэнээс ирүүлсэн хүнсний бүтээгдэхүүний 19 сорьцод 64 үзүүлэлт , ундны усны 15 сорьцод 76 үзүүлэлт, төмс хүнсний ногооны 71 сорьцод 184 үзүүлэлтээр нян судлал, хими хор судлал, хорио цээрийн шинжилгээ хийснээс ундны усны 4 сорьц 4 үзүүлэлтээр /магнийн хатуулаг, нянгийн тоо / стандартын шаардлага хангаагүй мөн хүнсний ногооны 3 сорьцод шавж /2

сорьцод манжингийн ялааны авгалдай, сонгины ялааны авгалдай/ илэрсэн. Төрийн тусгайгийн хоол, ундны ус, хүнсний бүтээгдэхүүний нийт 28 сорьцод 57 үзүүлэлтээр шинжилгээ хийхэд стандартын шаардлага хангаагүй сорьц илрээгүй болно.

Шинжилгээний төлбөр 769.3 мянган төгрөгийг бүрэн төвлөрүүлээ.

ЕС. СУМДАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ОНЦЛОГ АЖИЛ:

Есөнбулаг сум: Улсын төсвийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн хотын доторх нийтийн тээврийн 2 автобусыг хүлээн авч, цагийн хуваарь, маршрутын дагуу шугамын үйлчилгээнд явуулж, шугамын автобусны үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

Эрчим хүчний хэмнэлттэй дулаалга халаалтын бүтээгдэхүүн үйлчилгээний багцыг нэвтрүүлэх ажлын хүрээнд 50 өрхтэй гэрээ байгуулан, дулаалгын бүтээгдэхүүнийг олголоо. Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар намрын мод тарих өдөр болон “Ногоон –алтайдаа сайхан амьдарцаа-6” хөтөлбөрийн хүрээнд 10 дугаар сарын 09-ний өдөр Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлтэй хамтран 2000 мод тарилаа.

“Хан-Алтай ресурс” ХХК-ийн нийгмийн хариуцлагын хүрээнд 3.0 сая төгрөгөөр мал угаалгын ванн, “Болд гянт болд” ХХК-ийн нийгмийн хариуцлагын хүрээнд 7.0 сая төгрөгөөр хамгаалалтын бүсийн 2500 м2 газрыг тор татан хамгаалах ажлыг тус тус хийж гүйцэтгэлээ.

Алтай сум: Хүүхэд хөгжлийн чиглэлээр хэрэгжиж байгаа “Өөр өөр ертөнц” төслийн хүрээнд бага ангийн 7 бүлэгт тоглох өдөр зохион байгууллаа. Тоглох өдрийг 7 хоног бүрийн 1 өдөр зохион байгуулахаар төлөвлөн, хэрэгжүүлж байна.

Бага боловсролын багш нарын дунд “Сонирхолтой суралцахуй” жижиг хэрэглэгдэхүүний үзэсгэлэн гаргаж, 9 багшийн 60 гаруй төрлийн бүтээл тавигдаж, үлдэгдэлтэй хуваах, тооны бүтцийн абак, 50 бөглөөний уналт, тоглонгоо суралцах гэсэн хэрэглэгдэхүүнүүд шилдгээр тодорлоо.

Баян-Уул сум: 10 дугаар сарын 24-ний өдрөөс 27-ны өдрүүдэд Жаргалан сумын Соёлын төвтэй хамтран Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Манхан, Дарви сумдаар туршлага солилцож, аялан тоглолт хийж, харилцан суралцлаа.

Тус сумын номын сан цахим хаягаар зохиолчдын өгүүллэгүүдийг толилуулж байна.

Бигэр сум: Дарив, Хөхморьт, Шарга, Баян-Уул, Тайшир, Жаргалан, Бугат сумдын нутагт отроор амьдарч буй малчидтай уулзан, тухайн сумдын удирдлагуудтай гэрээ байгуулан ажиллаж байна.

Эн Си Жи Ти ХХК-тай байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд 10 дугаар сарын 28-ны өдөр 600 боодол өвсийг сумын аюулгүйн нөөцөд нөөцөллөө.

Бугат сум: Төрийн үйлчилгээний нэгдсэн систем буюу “Хур систем”-ээр 8 төрлийн лавлагааг нийт 18 иргэнд гарган өгч үйлчиллээ.

Сургуулийн гадаад, дотоод орчны эсрдэлийн үнэлгээг хийж, шаардлагатай газруудад тэмдэг тэмдэглэгээ хийж, сургууль орчмын бүсийг тогтоолоо.

Бага ангийн багш нар сургуулийн дотоод тохижилтод анхаарч, шатны хонгилыг бага насны хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохируулан хүүхдийн булан байгууллаа.

Дарив сум: Гадны аймаг, сумаас өвөлжих 57 өрхийн 35830 мал өвөлжихөөр судалгаа гарч, бэлтгэл хангагдаад байна.

Шарга сум: ЭМТ-ийн шинэ барилгыг 1387.4 сая төгрөгийн санхүүжилтээр “JTKS” ХХК гүйцэтгэж ашиглалтад хүлээн авч, 10 дугаар сарын 21-ний өдөр шинэ барилгын нээлтээ хийж, иргэдэд үйл ажиллагаагаа сурталчиллаа.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр тус сумд баригдаж буй толгойн барилгын засварын ажлыг ашиглалтад хүлээн авлаа.

Эрдэнэ сум: Авлигатай тэмцэх газрын Соён гэгээрүүлэх хэлтсээс 10 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан онлайн сургалтад төрийн байгууллагын 72 албан хаагч хамрагдаж, мэдлэгээ дээшлүүллээ.

ГИДЗГ-г 102 өрхийн 61306 мал гэрээгээр өвөлжихөөр судалгаа гарч, бэлтгэл ажил хангагдлаа.

Сумын эдийн засаг, нийгмийг хагжүүлэх 2020 оны үндсэн чиглэлд тусгагдсан “Алтайн ятга”-ыг залах арга хэмжээний хүрээнд хувийн 1.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Алтайн ятга”-ыг худалдан авч, Соёлын төвд байрлууллаа.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

